



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2007 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

“Даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл,
баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ
тогтоох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 14.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, нийтэд сурталчлахыг Тамгын газар /Ж.Жадамбаа/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАГЧААС ДААТГУУЛАГЧИД ТӨЛБӨРТЭЙГЭЭР
МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧИГ ӨГӨХ НӨХЦӨЛ,
ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ТОГТООХ ХЭМЖЭЭ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын тухай хуулийн 14.2.12 дахь заалтыг хэрэгжүүлж даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ДААТГАГЧААС ДААТГУУЛАГЧИД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ,
ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ**

2.1. Даатгагч даатгуулагчийн хүсэлтээр дараах мэдээллийг гаргаж өгнө:

2.1.1. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;

2.1.2. Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын хэлбэрийн талаарх мэдээлэл;

2.1.3. Даатгалын компанийн бизнес төлөвлөгөө;

2.1.4. Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу гаргаж, аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан;

2.1.5. Жилийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлан;

2.1.6. Сангийн сайдын 2004 оны 68 дугаар тушаалын дагуу гаргасан улирлын санхүүгийн тайлан;

2.1.7. Улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлан;

2.1.8. Давхар даатгалын төлөвлөгөө;

2.1.9. Аудит, бусад хяналтын байгууллагаас хийгдсэн тайлангууд;

2.1.10. Тухайн компанийн дотоодод мөрдөж буй эрх зүйн баримт, бичгүүд;

2.1.11. Даатгуулагчид өөрт нь холбоотой, үрэгдүүлж гээгдүүлсэн даатгалын гэрээ, гэрээний баталгааны хуулбарыг авах.

2.2. Даатгагч даатгуулагчид мэдээлэл өгөхдөө төлбөрийн хэмжээг дараах жишиг хэмжээг мөрдөнө:

2.2.1. Нэг нүүр баримт - 300 төгрөг;

2.2.2. Нэг нүүр тоон мэдээлэл - 500 төгрөг;

2.2.3. Жил, улирлын санхүүгийн тайлан - 1000 төгрөг;

2.2.4. Жил, улирлын төлбөрийн чадварын тайлан - 1200 төгрөг.

2.3. Даатгуулагч нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон даатгалын хэлбэрийн зөвшөөрлийн талаарх мэдээллийг даатгагчаас үнэ, төлбөргүй авах эрхтэй.

ГУРАВ. ХЯНАЛТ ТАВИХ

3.1. Даатгуулагчид шаардлагатай мэдээлэл өгөхөөс татгалзсан, даатгуулагчаас төлбөрийн жишиг хэмжээнээс илүү өндөр төлбөр авсан даатгагчид Даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--